## Іардугаар зуйл

### Хөндлөнгийн шуухийн шийдвэрийг хулээн зөвшөөрч гуйцэтгэх нөхцөл

Хэрэв энэхуу Гэрээний 57-р зуйлд заасан нөхцөлөөс гадна дор дурдсан нөхцлийг бурдуулсэн бол хөндлөнгийн шуухийн шийдвэрийг хулээн зөвшөөрч гуйцэтгэвэл зохино:

а/ хэрэв тодорхой эрхийн харилцаанаас уусэн гарсан хэлэлцэгдэж байгаа буюу хэлэлцэгдэх асуудлыг хөндлөнгийн шуухээр шийдвэрлуулэхээр бичигдсэн гэрээг ундэслэн шийдвэр гарсан бөгөөд хөндлөнгийн шуух нь харилцан тохкролцсон өөрийн эрх хэмжээнийхээ дагуу шийдвэр гаргасан бол;

б/ хэрэв хөндлөнгийн шуухэд маргааныг шийдвэрлуулэхээр шилжуулэх тухай хэлэлцээр нутад[1] дэвсгэрт нь шуухийн шийдвэрийг хулээн зөвшөөрч гуйцэтгэвэл зохих Хэлэлцэн Тохирогч Этгээдийн хуулийн дагуу хучин төгөлдөр байвал.

## Каран нэгдугээр зуйл

### Шийдвэр гуйцэтгэх тухай хусэлт

Шийдвэр гуйцэтгэх тухай хусэлтийг нутаг дэвсгэрт нь шийдвэр гуйцэтгэгдэх ёстой Хэлэлцэн Тохирогч Этгээдийн эрх бухий шуухэд эсхул уг шийдвэрийг гаргасан шуухэд туе туе өгөх бөгөөд тэгэхдээ хусэлтийг Хэлэлцэн Тохирогч нөгөө Этгээдийн эрх бухий шуухэд энэхуу Гэрээний 9-р зуйлд заасан хурмаар хургуулнэ.

2. Хусэлтэнд зайлшгуй хавсаргах зуйлууд:

а/ шуухийн албан ёсны шийдвэр буюу энэ шийдвэрийн батлагдеан хувь, хэрэв шуухийн шийдвэрт заагдаагуй бол тэр шийдвэр хуулийн хучин төгөлдор болж гуйцэтгэгдэх тухай албан бичиг барит;